ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/16 Сайншанд

Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Аялал жуулчлал хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013032

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/16 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.15. дахь заалт;

1.2. "Алсын хараа-2050" Монгол Улсыг урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн "Бүс, орон нутгийн хөгжил" Зорилт 8.2. Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ заалт;

1.3. Аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл;

1.4. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн 3.1.1.2, 3.1.1.4 дахь заалт;

1.5. Сэврэй сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх зорилгоор "Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, аялал жуулчлалын түр оператор, компаниудтай хамтран шинэ үйлчилгээг нэвтрүүлэн иргэд, малчид, бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ" заалтыг хэрэгжүүлэх.

Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага

Сумын газар нутгийн 82.09 хувь нь Улсын тусгай хамгаалалтад, үлдсэн хувь нь орон нутгийн хамгаалалтад байдаг. Монгол улсын болон Өмнөговь аймгийн 9 гайхамшгийн нэгээр тодорсон уртаашаа 130 гаруй км, өргөөшөө 3-20 км Хонгорын элсэн уул, түүний араар 10 гаруй км урт урсах Хонгорын гол болон Сэрүүн булаг, Нүдэн булаг, голын адагт орших Монгол орны баруун болон төвийн бүсийн нүүдлийн шувуудын дайран өнгөрч, зусдаг зам Адаг нуур, элсний хойд баруун хэсгүүдээр орших Цонжин хотгор, Зүүн, Баруун шургуул, Чоно харайхын гол, Тасархай цонж, Талын цүнхэг, Хоохорын тээг, Хун нуурын шал, Сэврэй уулын болон түүний өвөрт орших, эртний хүмүүсийн үлдээсэн түүх, соёлын үнэт өв хадны сүг зураг, Монголын их хөлгөн судрын нэрээр нэрлэгдсэн Ганжуур Данжуур хэмээх цохио, Гялааны ам зэрэг байгаль, түүх соёлын үзэсгэлэнт газруудтай юм.

Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 2019 оны 12 сарын 04 ны 9/10 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө 2019-2029 батлагдсан. Энэ төлөвлөгөөнд аймгийн газар нутгийн төвийн бүст байрших Даланзадгад- Булган сум, зүүн бүст байрлах Ханбогд сум, баруун бүст байрлах Хонгорын элсийг түшиглэсэн үндсэн гурван кластеруудыг тус аймгийн Аялал жуулчлалын хөгжлийн үлгэр жишээ, тэргүүлэх чиглэлүүд болгон сонгоно гэж заасан тул сум өөрийн хөгжлийн төлөвлөгөө, аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнүүдэд тулгуурласан "Аялал жуулчлалыг

хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг баталж үүгээр дамжуулан сумын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж ажлыг байрыг шинээр бий болгох бодлого барьж ажиллах шаардлага бий болж байна.

Хоёр. "Аялал жуулчлал хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн зорилго, зорилт хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл арга хэмжээ

2.1. "Аялал жуулчлал хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн зорилго

Бүс нутгийн үзэсгэлэнт байгаль, дэлхийд нэн ховор амьтан, ургамал, шувууд, түүх, соёлын үнэт өв, дурсгалт газрууд, уламжлалт нүүдэлчин малчин соёлдоо тулгуурлан орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх.

2.2. "Аялал жуулчлал хөгжүүлэх" хөтөлбөрийн зорилгыг доорх зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ:

2.2.1. Дотоодын болон гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэх

2.2.2. Хонгорын голын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, нутгийн иргэдийн аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх

2.2.3. Суманд үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудтай хамтран ажиллах харилцаа холбоог өргөжүүлэх

2.2.4. Аялал жуулчлалын салбарын эвент арга хэмжээг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан хөгжүүлэх, хамтран зохион байгуулах

2.2.5 Зам харилцаа, мэдээллийн технологийг сайжруулж орон нутгийн иргэд интернэт орчинд ажиллах, гадаад, дотоодын аялагчидтай шууд харилцах боломжийг бүрдүүлэх

2.2.6. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

"Аялал жуулчлал хөгжүүлэх" хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

2.2.1. Дотоодын болон гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэх

2.2.1.1. Сумын есөн гайхамшиг, байгалийн дурсгалт газар болон зэрлэг амьтад, шувууд харах тусгай зориулалтын аяллыг хөгжүүлэх

2.2.1.2 Смарт говь апп-д аялал жуулчлал эрхлэгч нарын мэдээллийг оруулж, сурталчлах

2.2.1.3 Монголын болон гадаадын аялал жуулчлалын салбарын жил бүрийн үзэсгэлэн, яармагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдээ оролцуулах

2.2.1.4. Дотоодын болон гадаад аялал жуулчлалын бүс нутагт туршлага судлах ажлыг зохион байгуулах

2.2.2. Хонгорын голын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, нутгийн иргэдийн аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх

2.2.2.1. Хонгорын голын мэдээллийн төвийн тохижилтыг сайжруулах, цахилгааны эх үүсвэрт холбох, барилга байгууламжийн бүрэн байдлыг хангах

2.2.2.2. Байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газруудын тухай, сумын нутаг дэвсгэрт зураг авалт хийгдсэн баримтат болон уран сайхны кинонуудыг мэдээллийн төвд тогтмол гаргах,

2.2.2.3. Хонгорын голын орчмыг Хонгорын голын хөгжил ТББ-д хариуцуулан өгч, шинээр ажлын байр бий болгох

2.2.2.4. Мэдээллийн төвд нутгийн иргэдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүн борлуулах цэг байгуулах, нутгийн иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх

2.2.2.5 Хонгорын голын бүс нутгийн даацын үнэлгээг хийлгэх,

2.2.2.6 Хонгорын голд хөв цөөрөм байгуулах

2.2.2.7 Хонгорын элсийг шинжлүүлэн элсний сувилал байгуулах боломжийг судлах,

2.2.2.8 Дуут манхны зогсоол дээр сүүдрэвчтэй болох

2.2.2.9. Сумын төв болон засмал зам дагуу үйлчилгээний төв байгуулах иргэдийг бодлогоор дэмжих

2.2.2.10. Унаган болон Ховор зүйл амьтдаа амьдрах, нүүдэллэн орших газар нутагтай нь унаган төрхөөр нь хадгалан хамгаалахад орон нутгийн иргэдийн нөхөрлөл болон хоршооны үйл ажиллагааг дэмжин ажиллаж, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, судалгааг хэрэгжүүлэх, хамтран ажиллах замаар орон нутгийн төсвийн орлого бааз суурийг нэмэгдүүлэх

2.2.3. Суманд үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудтай хамтран ажиллах харилцаа холбоог өргөжүүлэх

2.2.3.1. Хонгорын элсэнд үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд, гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтран “Хонгорын голын өнөөгийн байдал цаашид авах арга хэмжээ” зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж, зөвлөгөөнөөр бүс нутагт зохион байгуулах жуулчны улирлын хугацаанд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэх

2.2.3.2. Жуулчны баазууд, гэр буудал, үйлчилгээний газруудтай хамтран “Хонгор аялал” арга хэмжээг зохион байгуулах

2.2.3.3. Аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж жуулчны баазууд, гэр буудлууд хүнсний хэрэглээний боломжит хувийг орон нутгаас хангах

2.2.3.4. Хонгорын голын бүс нутагт гэр буудлын үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, гэр буудлын тоог нэмэгдүүлэхгүй байх

2.2.3.5. Хонгорын голын бүс нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг орон нутгаас ажилтан авч ажиллуулах талаар холбож өгөх

2.2.3.6. Суманд үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын ус ашигласны төлбөр, газрын төлбөр болон бусад холбогдох орлогыг орон нутагт төвлөрүүлэх,

2.2.3.7. Хонгорын гол дээр үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын ажилчдын цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

2.2.3.8. “Нүдэн булаг” амралтын газрын үйл ажиллагааны орлогоос сумын төсөвт орлого төвлөрүүлэх, тодорхой хувийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах

2.2.3.9. Аялал жуулчлал эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй малчин өрхтэй хамтран ажиллах талаар холбож өгөх

2.2.3.10. Гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгч нарыг и-баримт олгодог болгох

2.2.4. Аялал жуулчлалын салбарын эвентийг хамтран зохион байгуулах, уул овоо тахих арга хэмжээ орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан хийх

2.2.4.1. Жуулчны баазуудын санаачилга дэмжлэгтэйгээр уламжлал болон зохион байгуулагддаг "Хонгорын хурд" аялал жуулчлалын эвент наадмыг тогтмол зохион байгуулах

2.2.4.2. "Элсэн манхны баяр" эвент арга хэмжээг хамтран зохион байгуулах

2.2.4.3 Дашноров хайрхны тахилга, наадмыг зохион байгуулах

2.2.4.4. Элсэн парк байгуулах боломжийг судлах

2.2.5 Зам харилцааг сайжруулан тэмдэгжүүлэх, үйл ажиллагаа эрхлэгчдийн ажиллах боломжийг бүрдүүлэх

2.2.5.1. Аялал жуулчлалын бүс нутгийн замыг сайжруулах

2.2.5.2. Дуут манхан өөд гарах эко жим тавих

2.2.5.3. Хонгорын голын бүс нутгийн аялал жуулчлалын замыг тэмдэгжүүлэх

2.2.5.4. Хонгорын голын аялал жуулчлалын бүсийг 220 вольтын цахилгааны эх үүсвэрт холбох боломжийг судлах, зураг төсөл хийх

2.2.5.5 Аялал жуулчлалын бүс нутгаар зорчих маршрутыг гаргаж батлуулах

2.2.6 Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

2.2.6.1 Түүхийн дурсгалт газрын тооллого зохион байгуулж, кадастрт оруулах, гэрээт хамгаалагч нарыг урамшуулах

2.2.6.2 Хонгорын элс рүү зорин очих аялагчдыг орон нутгийн судлах танхимаар үйлчлүүлэх ажлыг эхлүүлэх

Гурав. Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөлтийг аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бусад хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгэм, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нягт уялдаатай харилцан зохицсон байдлаар хэрэгжүүлэх;

Хөтөлбөрийн зорилго үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуй нэгж, байгууллага, иргэний нийгмийн оролцоог дэмжиж өргөнөөр оролцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

Зорилт арга хэмжээнүүдийг аймаг сумын нийгэм, эдийн засгийг, хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах замаар хурдан шуурхай хэрэгжүүлэх

Дөрөв: Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн

Аялал жуулчлал хөгжин сумын төсвийн тодорхой хувийг аялал жуулчлалын үйл ажиллагаанаас оруулдаг болох. Орон нутагт шинэ ажлын байр бий болгох, Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн төвийн үйл ажиллагаа тогтмолжуулах.

Тав. Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2024-2028 онуудад хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлагаар хангах, зохицуулах, санхүүжилтийн эрх гаргуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

Зургаа. Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээ

6.1."Аялал жуулчлал хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг сумын ЗДТГ удирдан зохион байгуулна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүтэн жилээр сумын ИТХ-д тайлагнана

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг жилд 1 удаа хийж үр дүнг үнэлнэ.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд сумын ИТХ-ын Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хороо хяналт тавьж ажиллана.

Долоо: Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Улсын төсөв

7.2. Орон нутгийн төсөв

7.3 Орон нутгийн хөгжлийн сан

7.4. Байгаль хамгаалах сан

7.5. Аялал жуулчлал эрхлэгчдийн хандив тусламж

7.6. Уул уурхайн компаниудын хандив, тусламж

7.7. Олон улс болон гадаад дотоодын байгууллагын тусламж хандивын хөрөнгө

7.8. Иргэд хувийн хэвшлийн дэмжлэг

7.9. Бусад

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /оноор/			
			2024	2025	2026	2027	2028
	2.2.1 дүгээр зорилтын хүрээнд						
1	2.2.1.1. Сумын есөн гайхамшиг, байгалийн дурсгалт газар болон зэрлэг амьтад, шувууд харах тусгай зориулалтын аяллыг хөгжүүлэх	Аялалын тоо	0	2	3	3	4
2	2.2.1.2 Смарт говь апп-д аялал жуулчлал эрхлэгч нарын мэдээллийг оруулж, сурталчлах	Мэдээлэл оруулсан тоо	15	20	20	20	20
3	2.2.1.3 Монголын болон гадаадын аялал жуулчлалын салбарын жил бүрийн үзэсгэлэн, яармагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдээ оролцуулах	Оролцсон тоо	1	2	2	3	3

4	2.2.1.4. Дотоодын болон гадаад аялал жуулчлалын бүс нутагт туршлага судлах ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын тоо	3	4	5	5	5
	2.2.2 дугаар зорилтын хүрээнд						
5	2.2.2.1. Хонгорын голын мэдээллийн төвийн тохижилтыг сайжруулах, цахилгааны эх үүсвэрт холбох, барилга байгууламжийн бүрэн байдлыг хангах	Үйл ажилгааны хэрэгжилтээр %		50	70	90	100
6	2.2.2.2. Байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газруудын тухай, сумын нутаг дэвсгэрт зураг авалт хийгдсэн баримтат болон уран сайхны кинонуудыг мэдээллийн төвд тогтмол гаргах,	Үйл ажилгааны хэрэгжилтээр	1	2	3	4	5
7	2.2.2.3. Хонгорын голын орчмыг Хонгорын голын хөгжил ТББ-д хариуцуулан өгч, шинээр ажлын байр бий болгох	Ажлын байрны тоо	1	2	3	5	5
8	2.2.2.4. Мэдээллийн төвд нутгийн иргэдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүн борлуулах цэг байгуулах, нутгийн иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх	Үйл ажилгааны хэрэгжилтээр иргэний тоо	1	2	2	2	2
9	2.2.2.5 Хонгорын голын бүс нутгийн даацын үнэлгээг хийлгэх,	Үйл ажилгааны хэрэгжилтээр %	0		50		100
10	2.2.2.6 Хонгорын голд хөв цөөрөм байгуулах	Үйл ажилгааны хэрэгжилтээр %	0	100			
11	2.2.2.7. Хонгорын элсийг шинжлүүлэн элсний сувилал байгуулах боломжийг судлах,	Үйл ажилгааны хэрэгжилтээр %	0				100
12	2.2.2.8 Дуут манхны зогсоол дээр сүүдрэвчтэй болох	Сүүдрэвчны тоо	0		2		
13	2.2.2.9. Сумын төв болон засмал зам дагуу үйлчилгээний төв байгуулах иргэдийг бодлогоор дэмжих	Үйл ажилгааны хэрэгжилтээр %					
	2.2.3 дугаар зорилтын хүрээнд						

14	2.2.3.1. Хонгорын элсэнд үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд, гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтран "Хонгорын голын өнөөгийн байдал цаашид авах арга хэмжээ" зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж, зөвлөгөөнөөр бүс нутагт зохион байгуулах жуулчны улирлын хугацаанд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэх	Зөвлөгөөний тоо	1	1	1	1	1
15	2.2.3.2. Жуулчны баазуудтай хамтран "Хонгор аялал" арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний	1	1	1	1	1
16	2.2.3.3. Аялал жуулчлалын бүс нутагт үйл ажиллагаа явуулж жуулчны баазууд, гэр буудлууд хүнсний хэрэглээний боломжит хувийг орон нутгаас хангах	Үйл ажилгааны хэрэгжилтээр %	0	5	5	10	10
17	2.2.3.4. Хонгорын голын бүс нутагт гэр буудлын үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, гэр буудлын тоог нэмэгдүүлэхгүй байх	Үйл ажилгааны хэрэгжилтээр %					
18	2.2.3.5. Хонгорын голын бүс нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг орон нутгаас ажилтан авч ажиллуулах талаар холбож өгөх	Орон нутгийн ажилтны тоо		10	15	20	25
19	2.2.3.6. Суманд үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын ус ашигласны төлбөр, газрын төлбөр болон бусад холбогдох орлогыг орон нутагт төвлөрүүлэх,	Орлогын хэмжээ мян.төг	1.5	2.0	2.5	3.5	4.0
20	2.2.3.7. Хонгорын гол дээр үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын ажилчдын цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх	Орлогын хэмжээ сая.төг	0	2.0	3.0	3.5	4.0

21	2.2.3.8. “Нүдэн булаг” амралтын газрын үйл ажиллагааны орлогоос сумын төсөвт орлого төвлөрүүлэх, тодорхой хувийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах	Орлогын хэмжээ сая.төг	30.0	40.0	50.0	50.0	50.0
22	2.2.3.9. Аялал жуулчлал эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй малчин өрхтэй хамтран ажиллах талаар холбож өгөх	Үйл ажилгааны хэрэгжилтээр %					
23	2.2.3.10. Гэр буудлын үйл ажиллагаа эрхлэгч нарыг и-баримт олгодог болгох	Тоо	0	10	15	15	15
	2.2.4 дүгээр зорилтын хүрээнд						
24	2.2.4.1. Жуулчны баазуудын санаачилга дэмжлэгтэйгээр уламжлал болон зохион байгуулагддаг “Хонгорын хурд” аялал жуулчлалын эвент наадмыг тогтмол зохион байгуулах	Арга хэмжээний тоо	1	1	1	1	1
25	2.2.4.2. “Элсэн манхны баяр” эвент арга хэмжээг хамтран зохион байгуулах	Арга хэмжээний тоо	1	1	1	1	1
26	2.2.4.3 Дашноров хайрхны тахилга, наадмыг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	1	1	1	1	1
27	2.2.4.4. Элсэн парк байгуулах боломжийг судлах	Үйл ажилгааны хэрэгжилтээр %					
	2.2.5 дугаар зорилтын хүрээнд						
28	2.2.5.1. Аялал жуулчлалын бүс нутгийн замыг сайжруулах	Үйл ажилгааны хэрэгжилтээр %		20	40	60	80
29	2.2.5.2. Дуут манхан өөд гарах эко жим тавих	Үйл ажилгааны хэрэгжилтээр %					100
30	2.2.5.3. Хонгорын голын бүс нутгийн аялал жуулчлалын замыг тэмдэгжүүлэх	Үйл ажилгааны хэрэгжилтээр %		20	40	60	80
31	2.2.5.4. Хонгорын голын аялал жуулчлалын бүсийг 220 вольтын цахилгааны эх үүсвэрт холбох боломжийг судлах, зураг төсөл хийх	Үйл ажилгааны хэрэгжилтээр %	0	50	100		

-oOo-

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
03/16 дугаар тогтоолын хоёдугаар
хавсралт

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Сумын Засаг даргын орлогч

Гишүүдэд: Д.Мөнхжин (Сумын ИТХ-ын төлөөлөгч, Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга)

Сайншанд багийн Засаг дарга

Хоолт багийн Засаг дарга

Бүйлсэн багийн Засаг дарга

Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын Ирвэс хэсгийн ахлагч

Хонгорын голын хөгжил ТББ-ын дарга

Н.Энхмандах (Аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөлөл)

Засаг даргын Тамгын газрын Татварын байцаагч

Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалагч

Нарийн бичиг: Соёлын төвийн эрхлэгч

-oOo-